ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ” ХХК

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ОРА-2022 /98/НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Орхон аймаг<br>2022 он | Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Ц.Нармандах<br>Утас: 7035 9826<br>Цахим хаяг: orkhon@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Эрдэнэ<br>Утас: 7035 8505<br>Цахим хаяг: orkhon@audit.gov.mn<br>Аудитор: Б.Байгал<br>Утас: 99359854<br>Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ ....3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан (төгрөгөөр)....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....10
3.Аудитын тайлан....10
3.1 Ерөнхий зүйл....10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....12
3.4. Материаллаг байдал ....12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....17
3.8 Аудитын гол асуудал ....17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....19
4. Аудитын илрүүлэлт ....19
4.1 Залруулсан алдаа ....19
4.2 Төлбөрийн акт ....19
4.3 Албан шаардлага ....19
4.4 Зөвлөмж....19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....20

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| БОАЖЯ | Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам |
| ЗДТГ | Засаг Даргын Тамгын Газар |
| ЗГНХ | Засгийн Газрын Нөөц Хөрөнгө |
| ЗДНХ | Засаг Даргын Нөөц Хөрөнгө |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| НДШ | Нийгмийн Даатгалын Шимтгэл |
| ТШЗ | Төсвийн Шууд Захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| УБЕГ | Улсын бүртгэлийн ерөнхий газар |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин |
| ТЗ | Төрийн захиргаа |
| ТҮ | Төрийн үйлчилгээ |
| ХЧТАТ | Хөдөлмөрийн чадвараа түр алдалтын тэтгэмж |
| БОАЖГ | Байгаль орчин, аялал жуулчлалын газар |

## 1. АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn
2022.02.25 № 59
танай________-ны №________-т

ОРХОН АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА
С.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

**Аудитын санал дүгнэлт**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Орхон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт гаргах үндэслэл болно.

Хэмнэгдсэн цалингийн зардлаас ажилтан албан хаагчдад үр дүнгийн урамшуулалд 8,290.4 мянган төгрөг, Аймгийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлаар 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд зарцуулах санхүүжилтээс байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн төлбөр, спорт заалны түрээсийн төлбөр

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

нийт 5,950.0 мянган төгрөгийг зориулалт зөрчин олгосон нийт 14,240.4 мянган төгрөгийн материаллаг алдаа зөрчил гарсан нь 12,302.1 мянган төгрөгөөр тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түшингээс давсан байна.

Дээрх алдаа зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16.5.5.-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"-ын 1.2 дахь заалт "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх, зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.3 дахь заалт ". . . цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зардлыг гаргахгүй байх" гэсэн заалтыг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан (төгрөгөөр)

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **163,954,344.73** | **69,804,938.86** |
| **33** | **АВЛАГА** | 91,846,955.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 91,846,955.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 91,846,955.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 72,107,389.73 | 69,804,938.86 |
| **351** | **Түүхий эд материал** | 60,629,700.35 | 58,951,617.85 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 60,629,700.35 | 58,951,617.85 |
| **354** | **Хангамжийн материал** | 11,477,689.38 | 10,853,321.01 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 00.00 | 243,800.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 300,000.00 | 300,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,350,583.93 | 6,541,286.01 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,827,105.45 | 3,768,235.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **456,778,947.24** | **482,837,073.90** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 456,778,947.24 | 482,837,073.90 |
| **392** | **Биет хөрөнгө** | 307,012,280.50 | 334,750,407.36 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 74,384,726.49 | 74,384,726.49 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -7,361,074.56 | -11,041,611.84 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 95,627,560.00 | 95,627,560.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -67,945,615.40 | -73,562,282.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 100,893,083.30 | 102,300,263.19 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -66,660,916.79 | -63,367,021.52 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 59,583,378.72 | 58,656,978.72 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -42,049,203.45 | -46,271,428.74 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 190,428,343.37 | 247,549,480.37 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -29,888,001.18 | -49,526,257.31 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 149,766,666.74 | 148,086,666.54 |
| 39301 | Програм хангамж | 21,195,000.00 | 21,195,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -18,268,333.26 | -19,948,333.46 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 146,840,000.00 | 146,840,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **620,733,291.97** | **552,642,012.76** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **620,733,291.97** | **552,642,012.76** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 620,733,291.97 | 552,642,012.76 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 258,066,475.95 | 258,066,475.95 |
| 51101 | Өмч: - төрийн | 258,066,475.95 | 258,066,475.95 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 355,958,428.14 | 287,867,148.93 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 355,958,428.14 | 355,958,428.14 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -68,091,279.21 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 6,708,387.88 | 6,708,387.88 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **620,733,291.97** | **552,642,012.76** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,227,942,174.76** | **996,827,097.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **120,571,503.76** | **118,181,997.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 120,571,503.76 | 118,181,997.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 120,571,503.76 | 118,181,997.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 100,000.00 | 50,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 120,471,503.76 | 118,131,997.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,107,370,671.00** | **878,645,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | -23,377,600.00 | 00.00 |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | -2,937,600.00 | 00.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | -20,440,000.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,023,137,271.00 | 646,550,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,021,037,271.00 | 645,550,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,100,000.00 | 1,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 107,611,000.00 | 232,095,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 107,611,000.00 | 232,095,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,417,889,788.80** | **1,064,918,376.21** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,417,889,788.80** | **1,064,918,376.21** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,405,637,387.40 | 964,043,593.46 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 168,340,713.79 | 199,100,313.74 |
| 210101 | Үндсэн цалин | 115,927,036.00 | 127,227,244.00 |
| 210102 | Нэмэгдэл | 44,385,677.79 | 45,705,140.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,028,000.00 | 7,677,455.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 18,490,474.74 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,904,967.81 | 25,965,034.45 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,214,460.37 | 18,012,979.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,672,405.27 | 1,968,719.47 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,337,922.22 | 1,602,655.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 640,543.29 | 388,807.13 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,039,636.66 | 3,991,872.71 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,465,218.00 | 6,198,000.44 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,841,418.00 | 1,652,128.44 |
| 210302 | Түлш, халаалт | 1,385,100.00 | 1,395,872.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,238,700.00 | 3,150,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 47,065,031.33 | 66,615,550.99 |
| 210401 | Бичиг хэрэг | 804,050.00 | 1,131,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 44,625,117.33 | 52,367,297.92 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,156,464.00 | 1,297,882.62 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 101,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 479,400.00 | 600,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 11,117,870.45 |
| **2105** | **Нормативт зардал** | 7,200,000.00 | 8,259,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,200,000.00 | 7,995,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 264,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,130,000.00 | 45,698,442.50 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 43,638,442.50 |
| 210604 | Урсгал засвар | 2,130,000.00 | 2,060,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,544,700.00 | 700,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,544,700.00 | 700,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,115,084,373.00 | 570,858,041.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,113,297,171.00 | 568,457,596.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 720,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 207,144.00 | 213,840.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 332,058.00 | 192,405.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 473,000.00 | 473,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 757,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 37,902,383.47 | 40,648,510.34 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,220,000.00 | 720,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 36,682,383.47 | 39,928,510.34 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 12,252,401.40 | 100,874,782.75 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,839,988.00 | 9,150,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,839,988.00 | 9,150,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 7,412,413.40 | 91,724,782.75 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,412,413.40 | 6,033,348.66 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-189,947,614.04** | **-68,091,279.21** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-189,947,614.04** | **-68,091,279.21** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,477,618,400.00** | **970,448,429.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **100,000.00** | **50,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 100,000.00 | 50,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 100,000.00 | 50,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 100,000.00 | 50,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,477,518,400.00** | **970,398,429.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | -23,377,600.00 | 00.00 |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | -2,937,600.00 | 00.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | -20,440,000.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,393,285,000.00 | 738,303,329.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,391,185,000.00 | 737,303,329.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,100,000.00 | 1,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 107,611,000.00 | 232,095,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 107,611,000.00 | 232,095,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,477,618,400.00** | **964,448,429.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,477,618,400.00** | **964,448,429.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,373,612,669.60** | **863,573,646.25** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 169,393,696.79 | 199,006,687.74 |
| 210101 | Үндсэн цалин | 116,980,019.00 | 127,227,244.00 |
| 210102 | Нэмэгдэл | 44,385,677.79 | 45,705,140.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,028,000.00 | 7,677,455.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 18,396,848.74 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,904,967.81 | 25,965,034.45 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,217,458.37 | 18,012,979.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,672,405.27 | 1,968,719.47 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,337,922.22 | 1,602,655.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 334,480.05 | 388,807.13 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,342,701.90 | 3,991,872.71 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,465,218.00 | 6,198,000.44 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,841,418.00 | 1,652,128.44 |
| 210302 | Түлш, халаалт | 1,385,100.00 | 1,395,872.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,238,700.00 | 3,150,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 52,006,514.00 | 55,462,182.62 |
| 210401 | Бичиг хэрэг | 804,050.00 | 1,375,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 49,466,600.00 | 52,088,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,156,464.00 | 1,297,882.62 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 100,000.00 | 101,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 479,400.00 | 600,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 7,464,000.00 | 7,995,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,200,000.00 | 7,995,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 264,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,430,000.00 | 2,255,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 300,000.00 | 195,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,130,000.00 | 2,060,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,544,700.00 | 700,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,544,700.00 | 700,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,113,183,573.00 | 565,271,041.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,111,396,371.00 | 562,870,596.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 720,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 207,144.00 | 213,840.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 332,058.00 | 192,405.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 473,000.00 | 473,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 757,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,220,000.00 | 720,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,220,000.00 | 720,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **104,005,730.40** | **100,874,782.75** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,839,988.00 | 9,150,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,839,988.00 | 9,150,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 99,165,742.40 | 91,724,782.75 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 99,165,742.40 | 6,033,348.66 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **6,000,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **6,000,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **6,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 6,000,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 6,000,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-6,000,000.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 258,066,475.95 | 2,171,225.00 | 148,766,721.30 | 409,004,422.25 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **258,066,475.95** | **2,171,225.00** | **148,766,721.30** | 409,004,422.25 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 154,320,403.80 | 154,320,403.80 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **258,066,475.95** | **6,708,387.88** | **355,958,428.14** | 620,733,291.97 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **258,066,475.95** | **6,708,387.88** | **355,958,428.14** | 620,733,291.97 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **258,066,475.95** | **6,708,387.88** | **355,958,428.14** | 620,733,291.97 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -68,091,279.21 | -68,091,279.21 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **258,066,475.95** | **6,708,387.88** | **287,867,148.93** | 552,642,012.76 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 233,595,100.00 | 226,111,751.34 | 7,483,348.66 | 96.8 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 233,595,100.00 | 226,111,751.34 | 7,483,348.66 | 96.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 232,055,100.00 | 225,311,751.34 | 6,743,348.66 | 97.1 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 183,672,400.00 | 180,609,839.00 | 3,062,561.00 | 98.3 |
| 210101 | Үндсэн цалин | 127,566,400.00 | 127,227,244.00 | 339,156.00 | 99.7 |
| 210102 | Нэмэгдэл | 48,042,000.00 | 45,705,140.00 | 2,336,860.00 | 95.1 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,064,000.00 | 7,677,455.00 | 386,545.00 | 95.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 24,795,700.00 | 23,714,184.28 | 1,081,515.72 | 95.6 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,448,900.00 | 16,412,990.68 | 1,035,909.32 | 94.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,836,700.00 | 1,825,298.40 | 11,401.60 | 99.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,469,400.00 | 1,460,238.85 | 9,161.15 | 99.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 367,300.00 | 365,059.55 | 2,240.45 | 99.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,673,400.00 | 3,650,596.80 | 22,803.20 | 99.4 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 7,290,000.00 | 6,198,000.44 | 1,091,999.56 | 85.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,100,000.00 | 1,652,128.44 | 447,871.56 | 78.7 |
| 210302 | Түлш, халаалт | 1,890,000.00 | 1,395,872.00 | 494,128.00 | 73.9 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,300,000.00 | 3,150,000.00 | 150,000.00 | 95.5 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,560,000.00 | 8,414,182.62 | 145,817.38 | 98.3 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,518,400.00 | 1,375,300.00 | 143,100.00 | 90.6 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,040,000.00 | 5,040,000.00 | 0.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,300,600.00 | 1,297,882.62 | 2,717.38 | 99.8 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 101,000.00 | 101,000.00 | 0.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 600,000.00 | 600,000.00 | 0.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,370,000.00 | 2,255,000.00 | 115,000.00 | 95.1 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 200,000.00 | 195,000.00 | 5,000.00 | 97.5 |
| 210604 | Урсгал засвар | 2,170,000.00 | 2,060,000.00 | 110,000.00 | 94.9 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,800,000.00 | 700,100.00 | 1,099,900.00 | 38.9 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,800,000.00 | 700,100.00 | 1,099,900.00 | 38.9 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,847,000.00 | 2,700,445.00 | 146,555.00 | 94.9 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 300,000.00 | 300,000.00 | 0.00 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 720,000.00 | 0.00 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 270,000.00 | 213,840.00 | 56,160.00 | 79.2 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 194,000.00 | 192,405.00 | 1,595.00 | 99.2 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 90,000.00 | 44,000.00 | 46,000.00 | 48.9 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 473,000.00 | 473,000.00 | 0.00 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 800,000.00 | 757,200.00 | 42,800.00 | 94.7 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 720,000.00 | 720,000.00 | | 100 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 720,000.00 | 720,000.00 | | 100 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1540000.00 | 800000.00 | 740,000.00 | 51.9 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,540,000.00 | 800,000.00 | 740,000.00 | 51.9 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,540,000.00 | 800,000.00 | 740,000.00 | 51.9 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 233,595,100.00 | 232,145,100.00 | 1,450,000.00 | 99.4 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 232,095,100.00 | 232,095,100.00 | | 100 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 232,095,100.00 | 232,095,100.00 | | 100 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,500,000.00 | 50,000.00 | 1,450,000.00 | 3.3 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,500,000.00 | 50,000.00 | 1,450,000.00 | 3.3 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 14.00 | 14.00 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 08.00 | 08.00 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05.00 | 05.00 | 0.00 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **652,611,894.91** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **652,611,894.91** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 644,261,894.91 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 18,396,848.74 |
| 210104 | Урамшуулал | 18,396,848.74 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 2,250,850.17 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,599,988.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 143,421.07 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 142,416.77 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 23,747.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 341,275.91 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 47,048,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 47,048,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 7,995,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,995,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 568,570,596.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 568,570,596.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 8,350,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,350,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,350,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 738,303,329.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 738,303,329.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 737,303,329.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3.Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Орхон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын (цаашид “БОАЖГ” гэх) 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бараа материал, үндсэн хөрөнгө, урсгал зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК-ийн аудитор Э.Вандандулам гүйцэтгэж, хяналтыг гүйцэтгэгч талаас тус компанийн чанарын хяналтын менежер М.Бямбадорж, захирал, аудитор Б.Байгал нар, захиалагч талаас Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын

аудитын менежер, Б.Эрдэнэ, газрын дарга тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн БОАЖГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг "Мөнгө Нөөц Баялаг Аудит" ХХК-д 2022 оны 02 дугээр сарын 25-ны өдрийн 44 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Орхон аймгийн БОАЖГ-ийн байгууллагын Эрхэм зорилго нь "*Байгалийн нөөц баялгийг хамгаалах нөхөн сэргээх, орчны экологийн тэнцвэрт байдлыг хангах, хүний амьдрах*, *эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, байгаль орчны чиглэлээр төрөөс баримтлах бодлогыг аймгийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх, байгаль орчны хууль тогтоомжийн биелэлтэд төрийн болон технологийн хяналт тавих, байгаль орчны мэдээлэл сургалт, сурталчилгаа, сургалт явуулах, газар нутаг орон нутгийн онцлогийг харгалзан аялал жуулчлал хөгжүүлэхэд оршино* " гэж тодорхойлсон байна.

Тус газар нь дараах үйлчилгээг орон нутагт хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- ✓ Байгалийн нөөц баялгийг хамгаалах,
- ✓ Байгалийн нөхөн сэргээлтийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх,
- ✓ Байгалийн баялгийг зүй зохистой ашиглуулах,
- ✓ Байгалийн баялгийн төлөв байдалд мониторинг судалгаа хийж шаардлагатай арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх,
- ✓ Байгалийн баялгийг зүй зохистой ашиглуулахад технологийн хяналт тавих,
- ✓ Байгаль орчны бохирдлыг бууруулж хүний амьдрах эрүүл орчныг бүрдүүлэх,
- ✓ Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх,
- ✓ Байгаль хамгаалах үйлсэд иргэд, байгууллага аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх,
- ✓ Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ, ОНБ, иргэдийн нөхөрлөлүүдэд мэргэжлийн болон арга зүйн туслалцаа үзүүлэх,
- ✓ Бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх,
- ✓ Байгаль орчны хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж ажиллах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай багц хууль, Нийгмийн даатгалын тухай багц хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэгт 2021 онд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

БОАЖГ-ын дотоод хяналт шалгалт зохион байгуулах 2021 оны жилийн ажлын төлөвлөгөөг газрын даргаар батлуулж төлөвлөгөөндөө санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр 3 ажлыг тусгасан байна. Төлөвлөгөөний биелэлтээр өмч хамгаалах зөвлөл хөрөнгө актлуулсан, 4 албан хаагчийн зэрэг дэв нэмэгдүүлсэн. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт 83 хувь байгаа талаар тусгагдсан байна. Тайланд цаашид анхаарах ямар нэгэн зөвлөмжүүдийг өгөөгүй, ажил үүргийн хуваарьт багтсан ажлыг төлөвлөж тайлагнасан байна. Энэ нь дотоод хяналтын ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулах шаардлага байгааг харуулж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь төсвийн байгууллагуудад зориулан гаргасан нийтлэг баримт бичиг бөгөөд холбогдох хууль

тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн БОАЖГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсөв сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 971,898.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 19,437.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 13,606.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлын зөрүү 1,863.5 мянган төгрөгийн сөрөг зөрүүтэй гарсан. Тиймээс материаллаг байдлыг шинэчлэн тогтоох нь зүйтэй гэж үзэж шинэчлэн тогтоосон материаллаг байдал 17,574.5 мянган төгрөг, шинэчлэн тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдал 12,302.1 мянган төгрөг байна.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн БОАЖГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 68,091.3 мянган төгрөгөөр буюу 11 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүн данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | 2020.12.31 | 2021.12.31 | Өөрчлөлт | Хувь |
|---|---|---|---|---|
| Авлага | 91,847.0 | 0.0 | -91,847.0 | 0.0 |
| Бараа материал | 72,107.4 | 69,804.9 | -2,302.5 | 96.8 |
| Үндсэн хөрөнгө | 456,778.9 | 482,837.1 | 26,058.1 | 105.7 |
| Нийт хөрөнгө | 620,733.3 | 552,642.0 | -68,091.3 | 89.0 |
| Засгийн газрын хувь оролцоо | 258,066.5 | 258,066.5 | 0.0 | 100.0 |
| Хуримтлагдсан үр дүн | 355,958.4 | 287,867.1 | -68,091.3 | 80.9 |
| Хөрөнгийн дахин үнэлгээ | 6,708.4 | 6,708.4 | 0.0 | 100.0 |
| Нийт өр төлбөр өмчийн дүн | 620,733.3 | 552,642.0 | -68,091.3 | 89.0 |

Тус байгууллага нь Төрийн санд үндсэн болон нэмэлт санхүүжилтийн 2 данстай.

Үндсэн санхүүжилтийн харилцах 100210013001 тоот дансаар 232,145.1 мянган төгрөгийн орлого орж ирсэн байна. Орж ирсэн орлогын 226,111.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 33.4 мянган төгрөгийг нэр данс зөрүүг залруулж үлдэгдэл 6,000.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, уг данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Нэмэлт санхүүжилтийн 100210013401 тоот дансаар 458,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого, 182,200.0 мянган төгрөгийн эко нойлын санхүүжилт, шагналын санхүүжилт 3,000.0 мянган төгрөг, ЗД-ийн А/296 тоот захирамжаар арчилъя, ургуулъя аяны шагналын санхүүжилт 3,350.0 мянган төгрөг, урьд оны нэмэлт дансны авлага 91,753.3 мянган төгрөг, нэр данс зөрүү орлого 500.0 мянган төгрөг нийт 738,803.3 мянган төгрөгийн

орлого орсон байна. Орж ирсэн санхүүжилтийг үйл ажиллагааны зардалд 652,611.9 мянган төгрөг зарцуулсан, 500.0 мянган төгрөг нэр данс зөрүүг залруулсан, 85,691.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, уг данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 3.2%-аар буюу 2,302.5 мянган төгрөгөөр буурсан байна. Уг бууралтад дараах бараа материалуудын хөдөлгөөн нөлөөлсөн байна. Үүнд:

- Тусгай зориулалтын бараа материал өмнөх оноос 1,678.1 мянган төгрөгөөр буурсан. Үүнд: Үлдэгдэлтэй байсан 9,035.0 мянган төгрөгийн нормын хувцас хасагдсан, 5,875.0 мянган төгрөгийн 25 ширхэг цахилгаан халаалт хасагдсан, 2 төрлийн 343 ширхэг тулгат хийн зуух 56,675.3 мянган төгрөгийн өртөгтэй орлого орж 261 ширхэг 43,443.4 мянган төгрөгийн тулгат хийн зуух хасагдаж 41 тулгат хийн зуух буюу 13,231.9 мянган төгрөгөөр үлдэгдэл үлдэж нэмэгдсэн зэргээс шалтгаалсан байна.
- Бичиг хэргийн материал өмнөх онд үлдэгдэлгүй байсан энэ онд 243.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй үлдэж өссөн байна.
- Сэлбэг хэрэгсэл тайлант онд 1,930.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл авч зарцуулсан өмнөх оны үлдэгдэл 300.0 мянган төгрөг өөрчлөлт ороогүй
- Түлш шатах тослох материал тайлант онд 58,046.6 мянган төгрөгийн орлого орж 56,855.9 мянган төгрөгийн шатахууныг зарцуулж үлдэгдэл 1,190.7 мянга төгрөг нь өмнөх оны үлдэгдэл өсгөж 6,541.3 мянган төгрөг болж өссөн байна.
- Бусад хангамжийн материал тайлант онд 38,923.0 мянган төгрөгийн эд хогшил орлого орж 40,981.8 мянган төгрөгийн зарлага гарч үлдэгдэл 3,768.2 мянган төгрөг болж буурсан байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 5.7%-аар буюу 26,058.1 мянган төгрөгөөр өссөн нь 6,000.0 мянган төгрөгийн 1 хүхрийн давхар ислийн мэдрэгч худалдан авсан, 1 ширхэг компьютер хандиваар авсан, Ар булагын хашааг 27,599.6 мянган төгрөгөөр, Хөв цөөрмийн шинээр сольсон пилонкон дотрыг 29,521.5 мянган төгрөгөөр нэмж бүртгэсэн, 7,458.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 926.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил акталж хассан, тайлант жилийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Нийт өр төлбөр өмчийн дүн 68,091.3 мянган төгрөгөөр буюу 11%-аар буурсан. Үүнд: Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос өөрчлөлт ороогүй 258,066.5 мянган төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээ өөрчлөлт ороогүй 6,708.4 мянган төгрөг, тайлант үеийн үр дүн 68,091.3 мянган төгрөгөөр алдагдалтай гарсан нь нөлөөлсөн байна.

*Хүснэгт 2. Орлогын үзүүлэлт /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | 2020 он | 2021 он | Өөрчлөлт | Хувь |
|---|---|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 100.00 | 50.00 | (50.00) | 50.0 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 120,471.50 | 118,132.00 | (2,339.51) | 98.1 |
| Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | (2,937.60) | - | 2,937.60 | - |
| Хөрөнгийн санхүүжилт | (20,440.00) | - | 20,440.00 | - |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,021,037.27 | 645,550.00 | (375,487.27) | 63.2 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,100.00 | 1,000.00 | (1,100.00) | 47.6 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 107,611.00 | 232,095.10 | 124,484.10 | 215.7 |
| Нийт орлого | 1,227,942.17 | 996,827.10 | (231,115.08) | 81.2 |

2021 онд тус байгууллагын нийт орлого өмнөх оноос 231,115.08 мянган төгрөгөөр буюу 18.8%-аар буурсан байна. Үүнд, Үндсэн үйл ажиллагааны орлого 50.0 мянган төгрөгөөр буюу 50%-аар, Засаг даргын нөөц хөрөнгөөс хуваарилсан хөрөнгө 375,487.27 мянган төгрөг буюу, 36.8%-аар, БОАЖЯ-аас хуваарилсан хөрөнгө 1,100.0 мянган төгрөг буюу 52.4%-аар тус тус буурсан, Урсгал үйл ажиллагааны санхүүжилт 124,484.1 мянган төгрөг 124.5 хувь, өссөн зэрэг нь нөлөөлсөн байна. Орлогыг нэр төрөл тус бүрээр шинжилбэл дараах байдалтай байна. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны орлогот худаг гаргах зөвшөөрлийн орлого бүрдүүлдэг байна. Ойрын жилүүдэд энэ төрлийн зөвшөөрөл олгохгүй байгаа нь газар нутгийн багтаамжгүй болсонтой холбоотой бөгөөд цаашид орлого бүрдүүлэх боломжгүй, энэ онд буурсан нь үүнтэй холбоотой байна.
- Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оноос буурсан Энэ онд үнэ төлбөргүй орж ирсэн орлого нь бараа материалын бүртгэлд 56,675.4 мянган төгрөгийн тулгат хийн зуух, үндсэн хөрөнгийн бүртгэлд хөв цөөрмийн доторлогоо 29,521.5 мянган төгрөг, Ар булагын хашаа 27,599.6 мянган төгрөг, суурин компьютер 2,865.5 мянган төгрөг, түлш шатах тослох материалын бүртгэлд 1,470.0 мянган төгрөгийн урамшууллын шатахуун нийт 118,132.0 мянган төгрөг бүртгэгдсэн байна.
- Засаг даргын нөөц хөрөнгөөс хуваарилсан хөрөнгө өмнөх оноос буурсан. Энэ онд 42 төрлийн 645,550.0 мянган төгрөг авсан. Үүнийг бүлэглэн авч үзвэл ургамлан хашлагын арчилгаа, эко нойлын санхүүжилт 290,935.1 мянган төгрөг, мод тарих усалгаа арчилгаа хийх 208,829.1 мянган төгрөг, сургалт, судалгаа, шинжилгээ, тандалт, дүгнэлт гаргах 123,850.0 мянган төгрөг, шагнал урамшуулалд 21,935.8 мянган төгрөг тус тус багтаж байна.
- БОАЖЯ-аас нөлөөллийн ажил гүйцэтгэх 1,000.0 мянган төгрөг олгосон байна.
- Урсгал үйл ажиллагааны санхүүжилт 115.7% буюу 124,484.1 мянган төгрөгийн өсөлт гарсан байна.

*Хүснэгт 4. Зардлын үзүүлэлт /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | 2020 он | 2021 он | Өөрчлөлт | Хувь |
|---|---|---|---|---|
| УРСГАЛ ЗАРДАЛ | 1,477,618.4 | 964,448.4 | (513,169.97) | 65.3 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,373,612.7 | 863,573.6 | (510,039.02) | 62.9 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 169,393.7 | 199,006.7 | 29,612.99 | 117.5 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 20,905.0 | 25,965.0 | 5,060.07 | 124.2 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 4,465.2 | 6,198.0 | 1,732.78 | 138.8 |
| Хангамж, бараа материалын зардал | 52,006.5 | 55,462.2 | 3,455.67 | 106.6 |
| Нормативт зардал | 7,464.0 | 7,995.6 | 531.60 | 107.1 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 2,430.0 | 2,255.0 | (175.00) | 92.8 |
| Томилолт, зочны зардал | 2,544.7 | 700.1 | (1,844.60) | 27.5 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,113,183.6 | 565,271.0 | (547,912.53) | 50.8 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 1,220.0 | 720.0 | (500.00) | 59.0 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 104,005.7 | 100,874.8 | (3,130.95) | 97.0 |
| Бусад урсгал шилжүүлэг | 4,840.0 | 9,150.0 | 4,310.01 | 189.1 |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 99,165.7 | 91,724.8 | (7,440.96) | 92.5 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 99,165.7 | 6,033.3 | (93,132.39) | 6.1 |

Нийт зардал өмнөх оноос 34.7%-аар буюу 513,169.97 мянган төгрөгөөр буурсан байна. Үйл ажиллагааны зардлын бууралтын нөлөөлөл нь:

- ✓ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулагдаж байгаа хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн санхүүжилт өмнөх оноос 50.2% буюу 547,912.5 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.
- ✓ Цалин хөлс 17.5 хувь буюу 29,612.9 мянган төгрөг, НДШ-ийн зардал 24.2% буюу 5,060.1 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардал 6.6% буюу 3,455.6 мянган төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар Засгийн газрын хувь оролцооны нийт дүн 68,091.3 мянган төгрөгөөр буюу 10.9%-аар буурсан нь тайлант оны алдагдал нөлөөлсөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төлөвлөлтийг хийхдээ өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан төсвийн төсөл боловсруулж Орхон аймгийн төрийн санд хүргүүлдэг. Төсвийн төслийн санал файлаар болон цаасаар байхгүй байх тул харьцуулсан шинжилгээ хийгдсэнгүй.

Анхны батлагдсан төсөвт Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын А/478 тоот, 2021 оны 12 дугаар сарын А/746 дугаар захирамжуудаар 2 удаа нэмэлт тодотгол хийгдсэн.

Тус байгууллагын 2021 оны төсөвт зардал, уг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь 2021 оны байдлаар 233,595.1 мянган төгрөг болж тодотгосон байна. Эдгээртэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 5-д үзүүлэв.

*5 Төсвийн төлөвлөлтийн үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/*

| **Үзүүлэлт** | **Төсвийн төлөвлөгөө** | | **2021 оны тодотгол зөрүү** | **Хувь** |
|---|---|---|---|---|
| | 2021 оны анхны батлагдсан төлөвлөгөө | 2021 оны тодотгон батлагдсан төлөвлөгөө | | |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 216,431.00 | 233,595.10 | 17,164.10 | 107.9% |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 214,891.00 | 232,055.10 | 17,164.10 | 108.0% |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 168,549.80 | 183,672.40 | 15,122.60 | 109.0% |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 22,754.20 | 24,795.70 | 2,041.50 | 109.0% |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 6,090.00 | 6,090.00 | 0.00 | 100.0% |
| Хангамж, бараа материалын зардал | 8,400.00 | 8,400.00 | 0.00 | 100.0% |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 1,670.00 | 1,670.00 | 0.00 | 100.0% |
| Томилолт, зочны зардал | 3,000.00 | 3,000.00 | 0.00 | 100.0% |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,707.00 | 3,707.00 | 0.00 | 100.0% |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 720.00 | 720.00 | 0.00 | 100.0% |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,540.00 | 1,540.00 | 0.00 | 100.0% |
| Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 1,540.00 | 1,540.00 | 0.00 | 100.0% |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 216,431.00 | 233,595.10 | 17,164.10 | 107.9% |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 214,931.00 | 232,095.10 | 17,164.10 | 108.0% |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,500.00 | 1,500.00 | 0.00 | 100.0% |

Анхны батлагдсан төсвийн зарлага болох 216,431.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталжээ.

Төсөвт зардал, уг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь 2021 оны байдлаар 233,595.1 мянган төгрөг болж тодотгосон төсвийн дүн анхны батлагдсан төлөвлөгөөнөөс 7.9%-аар буюу 17,164.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Нэмж тодотгол хийхдээ цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 17,164.1 мянган төгрөг, НДШ-ийн зардалд 2,041.5 мянган төгрөг нэмэгдсэн байна. Харин байр ашиглахтай холбоотой 108.0 мянган төгрөг, хангамжийн бараа материалын 14.2 мянган төгрөг, эд хогшил худалдан авах 585.0 мянган төгрөгийн зардлуудыг албан томилолтын зардлаас гүйлгэх эрх олгож хооронд нь гүйлгэсэн байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 233,595.1 мянган төгрөгийн төсөв баталж орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 226,111.7 мянган төгрөг буюу 96.8% байна. Төсвийн гүйцэтгэлийн хэлбэлзлийг дараах хүснэгтээр харууллаа.

*Хүснэгт 6 Төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлт /мянган төгрөг/*

| **Үзүүлэлт** | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Өөрчлөлт** | **Хувь** |
|---|---|---|---|---|
| УРСГАЛ ЗАРДАЛ | 233,595.10 | 226,111.70 | 7,483.40 | 96.8% |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 232,055.10 | 225,311.70 | 6,743.40 | 97.1% |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 183,672.40 | 180,609.80 | 3,062.60 | 98.3% |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 24,795.70 | 23,714.20 | 1,081.50 | 95.6% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 7,290.00 | 6,198.00 | 1,092.00 | 85.0% |
| Хангамж, бараа материалын зардал | 8,560.00 | 8,414.20 | 145.8 | 98.3% |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 2,370.00 | 2,255.00 | 115.0 | 95.1% |
| Томилолт, зочны зардал | 1,800.0 | 700.1 | 1,099.9 | 38.9% |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,847.00 | 2,700.40 | 146.5 | 94.9% |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 720.00 | 720.00 | 0.00 | 100.0% |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1540.00 | 800.00 | 740.00 | 51.9% |
| Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 1540.00 | 800.00 | 740.00 | 51.9% |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 233,595.10 | 232,145.10 | 1,450.00 | 99.4% |
| Орон нутгийн төсвөөс | 232,095.10 | 232,095.10 | 0.00 | 100.0% |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,500.00 | 50.00 | 1,450.00 | 3.3% |

Тайлант онд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 3,062.6 мянган төгрөг, НДШ-ийн зардал 1,081.6 мянган төгрөг, томилолт, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 1,092.0 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардал 145.8 мянган төгрөг, эд хогшлын урсгал зардал 115.0 мянган төгрөг, зочны зардлаас 1,099.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 146.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллаас 740.0 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт үүссэн байна. Үүний үр нөлөөгөөр төсөвт зардал 3.2%-аар хэмнэгджээ. Харин орон нутгийн төсвөөс тайлант онд гүйцэтгэлээр 232,095.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоос 50.0 мянган төгрөг олж, үүнээс 226,111.7 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 6,033.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Оны эцсээр төсвийн хэтрэлт хэмнэлт гарсан тул БОАЖГ-аас 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн албан тоотоор зардал хооронд гүйлгэж өр авлагагүй болгох талаар хүсэлт гаргасны дагуу Аймгийн засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/746 тоот захирамжаар төсвийн зохицуулалт бүлэг хооронд гүйлгэсэн байна.

**Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого**

Аймгийн ИТХ-ын 2011 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор Ус хэрэглэгчдэд газрын доорх ус ашиглалтын цооног өрөмдөх зөвшөөрөл олгоход 150.0 мянган төгрөг байхаар тогтоосон. Дээрх тогтоолын дагуу тайлант онд олгосон зөвшөөрөл байхгүй байна. Мөн БОАЖ-ын сайдын 2018 оны А/376 дугаар тушаалын дагуу ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс 50.0 мянган төгрөг байхаар тогтоосон байна.

| № | Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Өөрчлөлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ус ашиглуулах, дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс | 1,500.0 | 50,0 | 1,450.0 | 3.3 |

Тус байгууллагын нэмэлт орлогын төлөвлөгөөг ус ашиглах, дүгнэлт гаргах үйлчилгээний төлбөрийн орлого олохоор тооцож жил бүр орлогын төлөвлөгөө тавьж өгдөг боловч Нэг дүгнэлт гаргасан байхад дахин дүгнэлт өөрчлөгдөх нь ховор. Энэ онд орсон орлого болох 50.0 мянган төгрөг орон нутгийн орлогот татан төвлөрүүлсэн дүнд багтан төвлөрүүлсэн байна.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дах заалтад “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 738,303.3 мянган төгрөгийн орлого орсноос 737,303.3 мянган төгрөг нь Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө, 1,000.0 мянган төгрөг нь БОАЖЯ-аас шилжүүлсэн орлого байна. Нийт орсон орлогоос 85,691.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийн тайлант онд зарцуулсан дүнг гүйлгээний утгаар ангилж харуулбал:

- ✓ Хөрөнгө оруулалтын шинжтэй ажлын олгосон дүн 435,885.1 мянган төгрөг,
- ✓ Сургалт судалгаа тандалт хийх ажилд 39,465.0 мянган төгрөг,
- ✓ Байгаль орчин, аялал жуулчлалын сургалт,Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, Бүх нийтээр мод тарих сурталчилгааны ажлын телевизийн зардалд 5,750.0 мянган төгрөг,
- ✓ Аялал жуулчлалын танилцуулга, тараах материалд 19,100.0 мянган төгрөг,
- ✓ Бичиг хэрэг, хөдөлмөр хамгаалал, эд хогшлын зардалд 23,282.5 мянган төгрөг,
- ✓ Мод тарих ном,ойжуулалт,төлөв байдлын тайлан, эко оо ном 8,560.0 мянган төгрөг
- ✓ Тогтвортой хөгжлийн төлөөх загвар сургуулиар сонгогдсон сургуулиудад дэмжлэг үзүүлэхэд 8,000.0 мянган төгрөг
- ✓ Агаарын бохирдол мастер төлөвлөгөөний хүрээнд хийгдсэн ажил 10,500.0 мянган төгрөг
- ✓ Үзэгслэнгийн талбай тохижилтын төлбөрт 5,129.4 мянган төгрөг,
- ✓ БОАЖГ-ын ажилчдын эрүүл ахуйн үзлэгийн төлбөр, заалны түрээс ахмад настанд хүндэтгэл үзүүлэх зардалд 6,350.0 мянган төгрөг,
- ✓ Бүх нийтээр мод тарих хаврын ажлын урамшуулал иргэдэд 900.0 мянган төгрөг,
- ✓ Олон улсын үзэгслэнд оролцогчдын замын зардалд 1,242.0 мянган төгрөг,
- ✓ Шатахууны зардалд 51,341.6 мянган төгрөг,
- ✓ Сайн дурын байгаль хамгаалагчдын цалин НДШ-ийн зардалд 20,647.7 мянган төгрөг,
- ✓ Хоол хүнсэнд 7,995.6 мянган төгрөг,
- ✓ Нэг удаагийн тэтгэмжид 8,350.0 мянган төгрөг нийт 652,498.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аймгийн БОАЖГ нь Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг 15 хүний орон тоотой, үндсэн чиг үүрэг нь байгаль орчны бодлого тодорхойлох, хяналт хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байхаар үйл ажиллагаа, зорилго зорилтоо тодорхойлсон байна. Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 435,885.1 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын шинжтэй санхүүжилт орж зарцуулагдсаныг санхүүгийн тайланд тусгасан байна. Эдгээр санхүүжилтээр гүйцэтгэсэн ажлуудын үр дүн, үр өгөөжийг тооцож, гүйцэтгэлийн шалгалтаар эсвэл тусгайлсан аудитаар үзэх, БОАЖГ-ийн нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулж тайлагнаж байгаа хөрөнгө оруулалтын ажил гүйлгээ нь төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт гаргахад Төрийн аудитын тухай хуулийн 8 дүгээр зүйл “Санхүүгийн тайлангийн аудит” 8.1.-т “*Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ.”* , Төсвийн тухай хуулийн 47.1.3.-д “*Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн* ***дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө***” заасан заалттай нийцэж байгаа эсэхийг үзэж шалгах аудит хийх шаардлагатай гэж үзлээ.

### 3.8 Аудитын гол асуудал

*Үндсэн хөрөнгийн дараа үеийн хэмжилттэй холбоотой асуудал*

Аймгийн БОАЖГ нь Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолд заасанчлан Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх агентлаг. БОАЖГ-ийн дансанд бүртгэлтэй байгаа үндсэн хөрөнгийн дансанд 172,361.1 мянган төгрөгийн түүхэн өртөгтэй, 82 нэр төрлийн машин, тавилга эд хогшил, тоног төхөөрөмж гэх мэт эргэлтийн бус хөрөнгө

байгууллагын хяналтад оршиж, ашиглагдсаар байна. Энэ нь тус байгууллагын үндсэн хөрөнгийн 23.1 хувийг эзэлж байна.

УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө"-ийн 44 дугаар параграф "*хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа, бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадах үндсэн хөрөнгийн зүйлийг түүний дахин үнэлсэн дүнгээр бүртгэж, тусгана. Тайлангийн өдрөөрх бодит үнэ цэнийг ашигласнаар тодорхойлсон дүнгээс дансны үнэ нь материаллаг зөрүүгүй гэдгийг хянан магадлахын тулд дахин үнэлгээг хангалттай тогтмол хийдэг байвал зохино.*", 49 дүгээр параграф "*Дахин үнэлгээний давтамж нь дахин үнэлж буй үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс шалтгаалдаг. Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит бодит үнэ цэнэ нь түүний дансны үнээс материаллаг өөр болсон тохиолдолд дараагийн дахин үнэлгээг хийх шаардлагатай байдаг*", 51 дүгээр параграф "*хэрэв үндсэн хөрөнгийн зүйлийг дахин үнэлэх бол тухайн хөрөнгийн харьялагдаж буй үндсэн хөрөнгийн нийт ангийг дахин үнэлнэ*" гэж тус тус заажээ. Стандартын дээрх заалтуудаар тоног төхөөрөмж, тавилга эд хогшил гэсэн хөрөнгийн ангид байгаа хөрөнгүүдийн дансны үнэ нь бодит үнэ цэнээсээ материаллаг ялгаатай үед тухайн ангид байгаа бүх хөрөнгийг дахин үнэлэхийг шаардаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 дугаарт "*илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*" гэж заасан байна.

Эдгээр стандарт болон хуулийн заалтуудад нийцүүлэн дээрх хөрөнгүүдийг үндсэн хөрөнгийн ангиар нь дахин үнэлж, нягтлан бодох бүртгэлд тусгах бодит хэрэгцээ, шаардлага байгааг бүх шатны төсвийн захирагч нар анхаарах нь зүйтэй юм.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг авч үзвэл, тайлант хугацаанд оруулбал зохих төсөв гүйцэтгэлийн 47, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалттай холбоотой 39, бусад 61, нийт 147 төрлийн мэдээлэл байршуулсан байна. Төсөв гүйцэтгэлийн 2 мэдээлэл оруулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Энэ тайлангийн аудитын илрүүлэлт хэсэгт тусгагдсан асуудлуудаас бусад хууль тогтоомжид нийцээгүй зүйл бидэнд ажиглагдаагүй болно.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 953.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, зөрчлийг арилгах 2 зөвлөмжийн өгсөн ба хэрэгжилт 100% хувьтай байна.

*Хүснэгт 7 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт* /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | | | |
| Албан шаардлага | 2 | 953.0 | 2 | 953.0 | | | |
| Зөвлөмж | 2 | | 2 | | | | |
| Нийт дүн | 4 | 953.0 | 4 | 953.0 | | | |

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 11 дугаар сарын 11-ны өдрийн 282 тоот албан бичгээр Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулагдаж байгаа зардлыг дараагийн аудитаар анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 20,781.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 14,240.4 мянган төгрөгийн материаллаг алдаа зөрчилд 2 албан шаардлага, 6,541.2 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа байхгүй залруулга хийгдээгүй.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тавигдаагүй болно.

### 4.3 Албан шаардлага

*5 1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал*

Энэ оны хэмнэгдсэн цалингийн зардлаас ажилтан албан хаагчдад нийт 8,290.4 мянган төгрөгийг шагнал урамшуулалд олгосон байна. Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол “*Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай*”-ын 1.3 дахь заалт *“. . . цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, . . .*” гэсэн заалтыг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*6 1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал*

Аймгийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлаар 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд зарцуулах санхүүжилтээс 5,950.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5.-д “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол “*Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай*”-ын 1.2 дахь заалт “*Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх, зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” 1.3 дахь заалт *“. . . цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зардлыг гаргахгүй байх.*” гэсэн заалтыг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Тайлант онд хэмнэгдсэн 6,541.2 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтээс дараа онд зарцуулах шатахуун худалдан авч нөөц үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 45.2-т "*Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ*" заасан заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Шатахууны үлдэгдлийг зохистой түвшинд барих, 2022 оны батлагдсан шатахууны зардлаас 6,541.2 мянган төгрөгийг хасаж орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэх,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Орхон аймгийн БОАЖГ | 3 | 20,781.6 | - | - | - | - | 2 | 14,240.4 | 1 | 6,541.2 |

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

БЭЛТГЭСЭН:

“МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ” ХХК-ИЙН

АУДИТОР: Э.ВАНДАНДУЛАМ Огноо:

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР М.БЯМБАДОРЖ Огноо:

АХЛАХ АУДИТОР Б.БАЙГАЛ Огноо:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ЭРДЭНЭ Огноо:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР: Ц.НАРМАНДАХ Огноо: